

## ШИЛДЭГ НИЙТЛЭЛИЙН ШИНЭХЭН БОТИЙН ТАЛААР ОНЦЛОН ТЭМДЭГЛЭХ ЦӨӨН ХЭДЭН ЗҮЙЛ

Т.Баасансүрэн\*

\*УБЭИС-ийн Сэтгүүл зүй, олон улс судлалын тэнхимийн эрхлэгч, доктор (PhD), профессор

**Түлхүүр үгс:** Телевизийн сэтгүүл зүйн бүтээлийг хэрхэн яаж урлан бүтээх арга аргачлал, зохиолын төлөвлөгөө. Теле зохиолын бүтэц, утга агуулга, ур чадвар. Телевизийн бүтээлийн шүүмж судлал. Монголын чөлөөт хэвлэл мэдээллийн өсөлт хөгжилт, сорилт бэрхшээл, ойрын хөгжлийн төлөв байдал. Сэтгүүл зүй, соёл урлагийн салбарын зарим зүтгэлтний хөргүүд.

**М**анай сэтгүүл зүйн телевизийн салбарын нэртэй том төлөөлөгчийн нэг, Монголын чөлөөт хэвлэлийн цогтой тэмцэгч, СУИС-ийн хүндэт профессор Х.Наранжаргалын бүтээл туурвилын дээжээр “Монголын шилдэг нийтлэл” цувралын 39 дүгээр ботийг бэлтгэж уншигчдад өргөн барьжээ. Үүнд бид ихэд баяртай байна. Баяртай байгаагийн учир гэвэл эл ботид түүний туурвисан уран бүтээлчдийн шилдэг хөргүүд, телевизийн бүтээлийг хэрхэн яаж урлаж бүтээх арга аргачлалаас гадна сүүлийн гучаад жилд Монгол Улсад гарсан телевизийн зарим нэвтрүүлэг, теле нийтлэл, теле жүжиг, телевизийн зохиолын бүтэц, ур чадвар, утга агуулга, ач холбогдлын

талаарх судлал шүүмжлэлүүд багтсанд байгаа юм.

Мөн Монгол Улсад чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа хэрхэн яаж үүсэж, хөгжиж, төлөвшиж байгаа, ямархуу сорилт бэрхшээлийг даван туулж эрийн цээнд хүрсэн хийгээд түүний ойрын ирээдүйн төлөв байдал яаж төсөөлөгдөж байгаа талаар профессор Х.Наранжаргал энд өөрийн үгийг хэлж, чөлөөт хэвлэл гэж ер нь юуг хэлэх, ардчилал хөгжсөн улс орнуудад яаж үүсэж хөгжиж өнөөг хүргэсэн, дэлхийн бусад улс оронд чөлөөт хэвлэлд хэрхэн яаж хандаж байгааг туйлын дэлгэрэнгүйгээр жишээ баримттайгаар өгүүлсэн нь танин мэдэхүйн болоод арга зүйн чухал ач холбогдолтой болсныг зориуд онцлон тэмдэглэж байна. Өнгөрсөн зууны ерээд онд Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн холбоог Ц.Дашдондов үүсгэн байгуулсан бөгөөд сүүлд тус холбооны дэд ерөнхийлөгчөөр Х.Наранжаргал сонгогдон үр бүтээлтэй ажиллаж Монголын сэтгүүлчдийн байгууллага, нийт сэтгүүлчдийг дэлхийн чөлөөт хэвлэл, тухайлбал Брюссельд төвтэй Олон улсын сэтгүүлчдийн байгууллагатай холбох гүүр болж

явалцсан гавьяатай хүмүүсийн нэгэн юм.

Чөлөөт хэвлэлийн мөн чанарыг ойлгож мэдрэх, улмаар түүний төлөө тэмцэгч болж хувирахад нь 1991 онд Их Британид очиж Лондон хотноо “Би Би Си” /BBC/ өргөн нэвтрүүлгийн корпорацад дадлага хийж суралцах ховорхон боломж олдсон нь, сүүлд Монголын сэтгүүлчдийг төлөөлж Олон улсын Сэтгүүлчдийн Холбооны Гүйцэтгэх хорооны гишүүний сонгуульт үүрэг хүлээж ажиллах болсон зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн нь ойлгомжтой юм. Яагаад гэвэл тэр бээр сэтгүүл зүйн салбарынхан дотроосоо хүний эрх, чөлөөт хэвлэлийн үзэл баримтлалыг гүн гүнзгийгээр анхалж мэдрэгч нь, тэр хэмжээгээрээ бас анхалж тууштай тэмцэгч, амьдрал практикт хэрэгжүүлэгч нь болж хувирч өөрчлөгдөж шинэчлэгдэж чадсан байдаг юм. “Би монгол телевизийн статусын тухай үргэлж боддог байв. “Би Би Си”-гийн үйл ажиллагаа гүн сэтгэгдэл төрүүлж нөлөөлсөн байх л даа. Олон нийтийн телевиз бол улс орны хөгжилд асар их нөлөөлдөг, иргэдийг соён гэгээрүүлэх, нийгмийн ухамсар, үзэл бодлыг төлөвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг, уран бүтээлийн том үйлдвэрлэл гэдгийг сайн ойлгосон байлаа. Нөгөөтээгүүр чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн үзэл баримтлалыг сэтгэлдээ бүрэн дүүрэн зөвшөөрч байв” гэж Х.Наранжаргал “Хараат бус телевизийн төлөө ажилласан” дурсамждаа бичсэн нь үүнийг гэрчилнэ. Ийм итгэл үнэмшилтэй хүн өнгөрсөн зууны ерээд оны эхээр тийм ч олон байгаагүй юм.

Х.Наранжаргалын “Шилдэг нийтлэл”-ийн 39-р боть түүний Сэтгүүл зүйн болоод танин мэдэхүй, судалгаа-

ны бүтээлүүд, “Телевиз миний амьдралд” дурсамж бичээс хийгээд бусад шүүмж судлалаас бүрдэж байна. Өөрийн гэсэн утга агуулга, өвөрмөц зохиомжтой эдгээр бүтээл үзэг нэгт нөхдөдөө санаа авхуулах бэлээхэн түүхий эд, санамж болох туршлагаар элбэг баян болжээ.

**Н**омын зохиогч өөрийн номын “Оршлын оронд: Ухаантай хүн бусдад дандаа боломж олгодог” хэмээх өмнөх үгэндээ “Хүн бүрийн амьдралд эргэлт өөрчлөлт гардаг чухал мөч байдаг. Миний хамгийн анхны ийм мөч 1972 онд тохиосон юм. Би сэтгүүлч болох хүсэлтэй, харамсалтай нь манай сургуульд сэтгүүлчийн хуваарь ирсэнгүй. Би МУИС эсвэл Багшийн дээд сургуулийн монгол хэлний ангид орохоор төлөвлөж байлаа. Нэг өдөр Умсхан багш /түүний анги даасан багш аж Т.Б/ “Нараа минь чи гадаадад сургуульд явсан нь дээр. Ямар ч мэргэжлээр сурсан чи алдахгүй. Хэл сурна, бас гадаадын соёлтой танилцана. Энэ бол чиний амьдралын том боломж” гэлээ. Хайрлаж хүндэтгэж явдаг багшийн минь зөвлөгөө намайг зөв сонголт хийхэд нөлөөлсөн. Багш минь ингэж миний амьдралын замыг заасан билээ... Ухаантай хүн бусдад дандаа боломж олгодог” гэжээ.

Ингээд ЗХУ-ын /Одоогийн ОХУ/ Уралын политехникийн дээд сургуулийн дулааны инженерийн ангийн хуваарь авчээ. Аз болоход уг сургуулийн оройн ангид сэтгүүлчийн мэргэжлээр элсэлт авдаг байсан байна. Х.Наранжаргал өдрөөр дулааны инженерийн анги, оройгоор сэтгүүлчийн ангид зэрэгцүүлэн суралцаж Уралын Политехникийн дээд сургуулийг /УПИ/ хос дипломтой буюу хоёр мэргэжлээр 1979 онд төгсөж ирээд

Улаанбаатарын шугам сүлжээний газарт дагалдан инженерээр ажиллах болсон байна. Гэвч сэтгүүлчийн мэргэжлээр ажиллах хүүхэд үеийн хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдсөөр байв. Төв телевиз дээр очиж холбогдох хүмүүстэй уулзаж санал хүсэлтээ илэрхийлсэн аж. Үүнийг нь гярхай ажиглаж хүсэл сонирхол чинь хэвээрээ бол ирж уулзахгүй юу гэж урьсан хүн нь Жаргал дарга юм байна. Хүсэлтээ тавиад дөрвөн сар өнгөрч бараг итгэл алдарч байхад нь төв телевизийн дарга ийнхүү дууджээ. Тэр тухай номдоо тун сонирхолтойгоор өгүүлжээ.

Сүүлд сэтгүүлчийнхээ мэргэжлээр Монгол телевизэд ажиллаж байх үед ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын анхны дарга, Ардын жүжигчин Э.Оюун гуайг байгууллагын захиргаа нь урьж “Уран бүтээлчийн үүрэг, хариуцлага” гэсэн сэдвээр нийт ажилтнууддаа лекц уншуулсан юм байна. Энэ нь театрын урлагийн тэр том зүтгэлтэнтэй танилцаж, улмаар ойртон дотносох үүд хаалгыг нээж өгчээ. Нэг удаа Улсын драмын театрын хашаанд явж байхад нь Э.Оюун гуай түүнийг араас нь гүйцэж ирээд

-Наранжаргал аа, чи жаахан биеэ тоох гээд байна аа даа гэжээ

-Яалаа гэж дээ Оюун гуай гэхэд нь

-Телевизийн дуран хүний дотоод нэвтрэх увдистай. Чи хэчнээн үгүй гэсэн ч дуран чамайг илчилж байна даа. Чи гайгүй байгаа. Гэхдээ ямар ч сайхан юм хэтрэхээрээ л муухай болдог. Бодоорой. Биеэ тоох гэдэг уран бүтээлч хүнд байх ёсгүй зүйл. Энэ бол юу ч мэдэхгүй хүний зан юм. Хүн бүр өөрийнхөө сэтгэлээс зэрлэг ургамлаа тасдаж хаях хэрэгтэй гэж

хэлчхээд түүнийг орхин тожигнон явж одсон байна.

“Би түүнийг театрын хаалга татан ортол араас нь харан нэг хэсэгтээ хөдөлгөөнгүй хөшив. Магадгүй миний дотор байсан жаахан аархал хийрхлийг олж харсан байх. Тэгэхэд би Монгол телевизийн Соёл урлагийн редакцад ажиллаж байв. Түүнээс хойш нэвтрүүлэг хөтлөхөөр, эсвэл ярилцлага авахаар дурангийн өмнө суух, зогсох бүрд энэ явдал санагдана.

Энэ дурсамжийн үнэ цэнийг өнөөдөр үнэлж баршгүй, энэ нь миний амьдралын зарчим, үнэт зүйл бүрэлдэхэд асар их нөлөө үзүүлсэн билээ. Мөн өөрийгөө уран бүтээлч гэж боддог хүн бүрд, телевизийн хөтлөгч, сэтгүүлч бүрд зориулсан мэргэжлийн ур чадварын тухай алтан сургаал гэж бодно” хэмээн тэр бээр “Зэрлэг ургамлаа тасдаж хаях хэрэгтэй” гэсэн нийтлэлдээ бичсэн байна.

**Х**.Наранжаргалд тохиолдсон, насан туршид нь мартагдалгүй бодогдож яваа эл хоёр дурсамжийг би зүгээр санамсаргүй энд иш татсангүй. Энэ эрдэмлэг эмэгтэй хэн бэ? Хэрхэн яаж уран бүтээлдээ ханддаг, сэтгүүлчийн хувьд хүмүүстэй харилцдаг болохыг тодотгох үүднээс зориуд эшиллээ.

Түүний бичсэн уран бүтээлчдийн хөргүүд, ялангуяа теле ярилцлагууд нь мэдлэг мэргэжил зааж бичсэн, ур чадварын өндөр түвшинд зохиомжлогдсон нь онцгой сонирхол татна. Залуу сэтгүүлчид, сэтгүүл зүйн ангийн оюутнуудад бол амт шимтэй хужир л гэсэн үг. Бэлэн загвар, бичлэгийн аргачлал юм.

Би заримаас нь эш татна. Тэгэхдээ эхлээд өмнө цухас дурдаад өнгөрсөн сэтгүүл зүйн төлөөлөл болох

нэг эрхмийн талаарх бичлэг дээр нь бяцхан ажиглалт хийж үзэцгээе.

Энэ бол Х.Наранжаргалын “Телевизийн буурал Жаргал” хөрөг болно. 7,5 хуудас уг нийтлэлд Монгол телевизэд насаа элээсэн Жаргал гэдэг сэтгүүлчийн үйл амьдрал, дүр төрхийг дурайтал товойлгон гаргажээ. Зах зухаас нь сонирхуулъя.

“Жаргал даргын тухай хүн бүр өөрийн бодолтой, хүн бүр түүнийг өөрийнхөөрөө ойлгоно, дүгнэнэ. Зарим нь сайн хүн гэх. Зарим нь түүн шиг муу хүн байхгүй гэх. Тэр бусдын адил нөхөдтэй, бас дайсантай. Гэсэн хэдий ч “Телевиз түүний амьдрал” гэвэл маргах хүн цөөн гарах байх.

Тэр нэг дарга болно, нэг цэрэг болно. Жаргал дарга одоо тэтгэвэрт, бидний хэлж заншсанаар гавьяаныхаа амралтыг эдэлж байгаа. Гэхдээ бидний хувьд мөнхийн дарга. “Телевизийнхээ хашаанд үхнэ гэж нэгэнтээ хэлж билээ. Магадгүй” гэсэн үг, өгүүлбэрээр энэ нийтлэл эхэлж байна.

Жаргал гэдэг даргын тухай аж. Зарим хүнд сайн, зарим хүнд муу харагдах энэ хүн анд нөхөдтэй, бас арсалдах дайсантай гэнэ. Хүн бүр түүнийг өөр өөрийнхөөрөө ойлгож дүгнэдэг ч “Телевиз түүний амьдрал” гэхэд маргах хүн бараг гарахгүй гэжээ.

**Э**нэхүү эхлэлээ зохиогч тэр нэг дарга болно, нэг цэрэг болно. Одоо бол тэтгэвэртээ сууж байгаа. Гэхдээ бидний хувьд бол мөнхийн дарга. “Телевизийнхээ хашаанд үхнэ гэж нэгэнтээ хэлж билээ. Тун магадгүй” хэмээн араас нь залгуулж дараагийн үг, өгүүлбэрээр анхны санаагаа улам гүнзгийрүүлэн бататгаж өгчээ. Өөрөөр хэлбэл нийтлэлийн улаан шугамаа маш тодорхой зурж томъёолсон байна. Эндээс энэ нийтлэлийг ихээхэн туршлагатай,

мэргэжлийн өндөр мэдлэгтэй, торгон мэдрэмжтэй, чадварлаг үгийн мастер туурвижээ гэдэг нь шууд мэдрэгдэж байгаа юм. Нийтлэлийн баатар Жаргал нэг дарга болж, нэг цэрэг болж сонин бөгөөд содон амьдралыг туулжээ гэдэг нь ойлгогдож байна. Уншигчдыг гижигдэж унших сонирхлыг нь зохиогч өдөөн бадрааж байна гэсэн үг. Тэгэхдээ тэр Жаргал гэгч этгээд нь Х.Наранжаргал нарын телевизийн мэргэжлийн сэтгүүлчдийн хувьд “мөнхийн дарга” нь юм байна. Бидний хувьд бол тэр мөнхийн дарга гэсэн үг өгүүлбэр нийтлэлийн баатарт хандах зохиогчийн дотоод сэтгэл, үндсэн хандлагыг нь тодорхойлж, залгуулаад өгүүлсэн “Телевизийнхээ хашаанд үхнэ гэж нэгэнтээ хэлж билээ. Магадгүй” гэсэн нь Жаргал гэдэг энэ хүний ухамсарт бүх амьдрал Монгол телевизтэй холбоотой юм байна гэсэн ойлголт, төсөөллийг уншигчдад өгч байна.

Маш чамбай, тун оновчтой, зөв эхлэл болжээ. Энэ бүхнийхээ дараа Х.Наранжаргал сая “Хөнгөн дэврүү, залуу халуун, гэнэн томоогүй миний хөлийг дөрөөнд, гарыг ганзаганд хүргэж телевизийн хүн болгосон ачтан билээ, Жаргал дарга” хэмээн үргэлжлүүлжээ. Анх уулзахад нь “тас хар халимагтай залуу дарга ширээнийхээ ард сууж” байж. Тэгсэн атлаа зохиогч нийтлэлээ “Буурал Жаргал” гэж гарчигласан нь бас л гижиг хөдөлгөж байгаа нэг шигтгээ. Гарчгийг оновчтой олж тавина гэдэг бол том авьяас юм. Хав хар халимагтай залуу дарга був буурал толгойтой “Буурал Жаргал” гэж нэрлэгдэх хүртэлх амьдралын урт замнал, хувь заяаны эргэлтийн сонин содныг долоохон хуудсанд багтааж гаргана гэдэг бол бараг боломжгүй

зүйл. Гэвч Х.Наранжаргал гаргаж чадсан л байгаа юм.

Ингээд инженер-сэтгүүлч Х.Наранжаргал телевизийн удирдлагын даалгавраар хүүхэд багачуудад зориулж бүтээсэн “Шинжлэх ухаан техник” нэвтрүүлгийнхээ анхны дугаарыг 1980 оны 1 дүгээр сарын 8-нд эфирт гаргажээ. Маргааш нь Жаргал дарга түүнийг дуудаж “Дөнгөж орноосоо боссон юм шиг толгойтой эфирт битгий гарч бай. Явж ажлаа хий” гэсэн байна. Уг нь залуу бүсгүй Х.Наранжаргал тухайн цаг үед ид моодонд орж байсан “гарсон” маягаар үсээ засуулж хэрэндээ л гоёж гоодсон байсан боловч төв телевизийн даргаасаа “жавтий” хүртсэн байна. Эндээс Жаргал дарга энэ айл гэрийн эзэн гэдэг нь их тод харагдаж байгаа юм. Тэр сэтгүүлч бүрийн нэвтрүүлэг, хөтөлбөрийг алгасалгүй үздэг, алдаа оноог нь хэлж өгдөг удирдагч байжээ.

Зөвхөн хэлж ярьж өгөх төдийгүй, урьдчилж сайтар бэлтгүүлдэг, өөрөөр хэлбэл залуу сэтгүүлчидтэй тулж ажилладаг, туршлага дадлага эзэмшүүлдэг дарга байсан нь Х.Наранжаргалын “Нэвтрүүлгийн зохиолыг Жаргал дарга уншина аа. Би текстээ уншаад л байна, уншаад л байна. Боллоо гэж бодоод Жаргал даргад өгнө. Дарга хар бэхтэй үзгээр цоохорлоод л байна, цоохорлоод л байна. Би засаад л байна, засаад л байна. Дарга эргээд л буцаана. Сүүлдээ уур хүрч, зохиолоо шургуулгадаа шидчихээд нэг хоёр хонох болов. Заримдаа “намайг тамлаж байна” гэж бодогдоно. Гэвч Жаргал даргын зөвшөөрөлгүй л бол бичлэгийн цаг ч өгөхгүй, унаа камер ч байхгүй. Уурлаад, гомдоод ч нэмэргүй. Тэр үед Жаргал даргын өмнөөс үг хэлэх зүрх, зориг байх биш. Үнэндээ ч би Орост

олон жил сураад эх хэлээрээ бичих нь битгий хэл, худлаа хэлсэн хүнд уншаад дутуу дулимаг ойлгодог эрлийзсэн амьтан шиг болчихсон байв. Модон хэлтэй намайг “монголжуулж” байсан нь тэр” гэж бичсэнээс тодорхой ойлгогдож байгаа юм.

Эндээс Монгол дахь өнгөрсөн зууны дал наяд оны хэвлэл мэдээллийн удирдагчдын нийтлэг дүр төрх, арга ажиллагаа шууд харагдаж байна. Төр засгийн төв хэвлэл “Үнэн” сонины ерөнхий эрхлэгч Лодонгийн Түдэв ахайтан, “Цог” сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга Өвгөөдэй хэмээх Ц.Дамдинсүрэн гуай нар яг ингэж ажилладаг байсан. Сүүлд миний мэдэхээс тэдний буухиаг “Ардын эрх”, “Өнөөдөр” сонинд Баарангийн Пүрэвдаш, “Улаанбаатар” сонинд Ядамжавын Сумьяа нарын зэрэг “ас”-ууд хүлээж авч үргэлжлүүлсэн юм даг. Залуусын бичлэгтэй залхууралгүй ажиллаж үг хэллэг, найруулгыг өөд татаж сайжруулахаас энэ эрхмүүд ер хойш суудаггүй байв. Жаргал дарга тэдний нэг байжээ. Тэр үед төв телевизэд бараг гурван жил ажиллаж байж л сая нэг телевизийн хүн болдог байлаа гэж Х.Наранжаргал дурсан бичжээ. Энэ үнэн. Өчигдрийн нийтлэг дүр зураг үнэхээр тийм байсан.

Өнөөдөр тэгвэл байдал ямар байгаа билээ гэж бодоход сэтгэл сүрхий эмзэглэж байна. Хүнтэй, хүний бүтээлтэй Жаргал дарга шиг сэтгэл гаргаж ажилладаг хүн үгүй болжээ. Хэн яаж бичсэн нь сонин, сэтгүүлийн хуудаснаа, радио, телевизийн эфирт тэр чигээрээ л гардаг болсон. Сэтгүүлчийн бүтээлийн чанар тэр хэмжээгээр суларч уншигч, үзэгч, сонсогчдоо алдсаар байгаа нь нууц биш. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл,

сэтгүүлчдийн нэр хүнд нийгэмд унаж буйн нэг учир шалтгааныг тэдний бүтээл туурвилын чанараас эрж хайх нь зохилтой.

Зарчимч хатуу шаардлагатай Жаргал даргаасаа залуу сэтгүүлч Х.Наранжаргал байнга бултан зайлсхийж халз тулгарахаасаа айж болгоомжилдог байснаа их л хөгжилтэй өгүүлсэн байна. 1980 онд Монгол телевизийн захиргаа түүнд Майн баярын жагсаалын талаарх сурвалжилгын зохиол бичих үүрэг даалгавар өгчээ. “Би айж, гайхаж байв. Нэгэнт дарга тушаасан хойно бичихээс яах вэ. Бичиж бичиж эргээд уншихад төгсгөл нь ижил болчихно. Арайхийж бэлэн болгож, Утга зохиолын нарийн бичгийн дарга, яруу найрагч Т.Очирхүүгийн гараас гаргаж, Жаргал даргад өгтөл хар эрээн цаас буцаж ирэв. Ахиад л заслаа. Дахиад л хар эрээн. Тэр зохиолыг хэд дахин бичсэнийг бүү мэд. Ямартай ч Майн баярын урд өдрийн орой 8 цагт Жаргал даргын гарын үсэгтэй зохиолоо хүлээлгэж өгөөд сэтгэл цэлмэж билээ” хэмээн Х.Наранжаргал бичжээ.

Эндээс төв телевизийн дарга Жаргалын ажлын хариуцлага, сэтгүүлч Х.Наранжаргалын уйгагүй, хичээнгүй мэрийлт аль аль нь зэрэг зэрэг мэдрэгдэж байна. Зохиолоо хүлээлгэж өгөөд сэтгэл цэлмэж билээ гэсэн төгсгөл өгүүлбэр нүдэнд тун содон тусч, сэтгэлд нэн таатай санагдана. “Сэтгэл цэлмэж” гэсэн хоёрхон үг л агуулга, ухагдахууныг сэвхийтэл өргөөд, аваад явчхаж байгаа юм. Мэргэжлийн сэтгүүлчийн ур чадварыг үг сонголт, дүр дүрслэлээр нь үнэлж дүгнэж болдог. Эх хэлээ эзэмшсэн шиг эзэмшихийн зайлшгүй шаардлага энэ юм.

1980 онд Жаргал даргаар ахлуулсан сансрын баг төв телевизэд байгуулагдаж, түүний бүрэлдэхүүнд Х.Наранжаргал орж ажилласнаа, Жаргал даргаас маш их зүйлийг сурч мэдсэнээ зохиогч хөрөгтөө үнэмшилтэйгээр өгүүлсэн байна. “Сансрын мартагдашгүй өдрүүд” нэртэй тусгай тэмдэглэл хүртэл бичжээ. “Жаргал дарга маш их уншина. Өргөн хүрээтэй уншина. Тэр олон талын мэдлэгтэй, маш нарийн мэдрэмжтэй. Ажилдаа бусдаас түрүүн ирж, бусдаас сүүлд явна. Ар гэр, ахуй амьдрал гэхээсээ ажлаа эн тэргүүнд тавина. Түүнтэй хамт нэг багт ажилласандаа би өнөө хэр бахархаж явдаг. Тэр үеэс л миний айдас жийрхэл алга болж, би түүнийг дарга гэхээсээ илүүтэйгээр хүнлэг жирийн сайхан хүн гэж харах болсон билээ. Заримдаа ч зориглон өөдөөс нь цор цор хийх болов” хэмээн Х.Наранжаргал дурссан байна. “Цор цор хийх болов” гэсэн нь “сэтгэл цэлмэв” гэдэгтэй яг адилхан ончтой дүрслэл болжээ.

Х.Наранжаргал нэг удаа хичээлийн шинэ жилд зориулсан нэвтрүүлэг бэлтгэжээ. “Есдүгээр сарын нэгэн. Жил бүрийн энэ өдөр мөнгөн хонхны жингэнэсэн дуугаар сургуулийнхаа зүг яараагүй монгол хүн үгүй” гэсэн утгатай тайлбар сэлт хийгээд Жаргал даргадаа шилжүүлжээ. “Жаргал дарга нэвтрүүлгийг эфирт гаргах зөвшөөрөл өгч, гарын үсэг зурснаа:

-Битгий худлаа хэлж байгаач гэв

-Юу гэж худлаа хэлсэн юм бэ гэж би өрвөлзлөө

-Миний аав ээж хоёр л лав мөнгөн хонхны жингэнэсэн дуугаар сургуулийн зүг яарч байгаагүй

Энэ үгнээс хойш би “сэтгэлийн хөөрлөө дарж, үг бүрээ цэгнэх болсон” гэж Х.Наранжаргал бичсэн байна.

Түүнд насан туршийн сургамж болж үлджээ. Бас нэг удаа найрамдлын сард зориулсан тааруухан нэвтрүүлэг бэлтгэжээ. Үүнийгээ Х.Наранжаргал өөрөө сайн мэдэж байсан гэнэ. Жаргал дарга үзээд дүр дүрслэл, үг нэг бүрийг нь шүүмжилжээ. Гэнэт түүний гэдэн хөдөлж хэлсэн бүхнийг сөрж, өөрийгөө хамгаалсаар байжээ. “Жаргал дарга гарын үсэг зурлаа. Миний ичсэн гэж яав аа. Би өдөржин шаналав. Тэрний оронд намайг толгой түрүүгүй загнасан, эсвэл бүр цохиод авсан бол хамаагүй дээр байсан. Шөнө зүүдлэв. Жаргал даргын зангиаг засаж хацрыг нь илээд их долигонож байна. Маргааш нь өөрөөсөө, зүүднээсээ ичээд хэдэн өдөр Жаргал даргатай тааралдахаас зугтаж билээ.

**Э**нэ явдал надад алдаагаа шударгаар хүлээж сурахын том сургууль болсон юм” гэж Х.Наранжаргал бичжээ. Сонин агаад содон үйл явдал. Сургамжтай болоод уяралтай шигтгээ. Жаргал дарга бол түүний зүүдэнд орсон, зүрхэнд торсон удирдагч байжээ. Эл баримт нийтлэлийг улам амьд сонирхолтой болгож байна. Хамгийн гол нь монгол телевизийн даргын дүр төрхийг онцгой тод томруун болгож байгаа юм. Ийм шим шүүстэй гялтганасан гоё шигтгэ-эгээр “Телевизийн буурал Жаргал” нийтлэл элбэг баян байгаа нь олзуурхам. Өөр нэг жишээг эш татъя. “Ер нь Жаргал дарга хүнийг учиргүй толгой түрүүгүй доромжилж загнахгүй л дээ. Хэлсэн үг нь хорон, ёжтой ч цохиод авснаас илүү хүчтэй бууна. Жаргал дарга тэгж хэлсэн, ингэж хэлсэн гэх мэтээр үлгэр домог шиг яриа телевизээр нэг тарна. Би заримд нь итгэнэ, заримд нь итгэхгүй. Нэг удаа би “Цагийн хүрд”-ийн дараа бичлэгтэй тул хүлээгээд нэвтрүүлэх танхимын үүдэнд зогсож

байв. “Цагийн хүрд” дуусч, Жаргал дарга инженерийн өрөөнөөс, нэвтрүүлэгч Бямбаа нэвтрүүлэх танхимаас гарч ирэв.

-Бямбаа сайхан амарсан уу?

-Сайхан амарсан

-Тийм байх. Хэл чинь лав өөхөлчхөж гэж байна. Бямбаа бичлэгийн үеэр хэд хэд алдсан юмсанж” гэжээ. Ингэж хэлүүлсэн Бямбаа нэвтрүүлэгч сүрхий ичсэн байж таарна. Жаргал дарга хорон үгтэй, ёстой цохиод авснаас илүү хүчтэй бууна гэж Х.Наранжаргал үнэн бичсэн байна.

Энэ мэтээр сургаалтай сургамжтай, үлдэцтэй өгөөжтэй олон баримтыг эмхэлж цэгцэлж ихэд эвтэйхнээр энд тэнд тун чадмаг тараан байршуулж өгүүлэн шигтгэж өгснөөрөө “Телевизийн буурал Жаргал” нийтлэл үнэнхүү сонирхолтой, үлэмжийн содон хөрөг болж чадсан байна. Х.Наранжаргал өөрөө хүссэн эсэхийг би мэдэхгүй, ямар ч байсан өнгөрсөн зууны дал наяд оны удирдах албаны хүмүүсийн нийтлэг дүр төрх, түүний дотор Монгол телевизийн дарга Жаргалын дүрийг бүтээж чадсан байна. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлүүд дотор зөвхөн найруулалд буюу хөрөг найруулалд дүр бүтээх боломжтой байдаг. Энэ нь маш их хүч хөдөлмөр, эрэл хайгуул зарцуулж, ур чадварыг уралдуулж, мэдээ мэдээллийг цуглуулан уншиж судалж тоосго өрж цамхаг босгох адил хичээнгүйлэн сүндэрлүүлж байж бичдэг бичлэгийн гоёмсог хэлбэр мөн тул хэр баргийн уран бүтээлч зориглон барьж авахаас зүрхшээдэг юм. Х.Наранжаргалын үеийнхнээс хөрөг найрууллын жинхэнэ мастер нь Ш.Цэрэнпил байсан бөгөөд Цэрэнпилээр манайд хөрөг

нийтлэл шувтарсан гэж зарим судлаач тоглоом шоглоомоор хэлдэг нь үнэний ортой билээ. Үүнийг сэтгүүл зүйн зарим ядмаг судлаач орчин үед бичлэгийн бүх төрөл, зүйл хоорондоо холилдон бие биедээ уусан шингэж нийлэгжээд бие даасан бичлэгийн хэлбэр алга болж байгаа. Энэ нь бараг өнөөгийн хөгжлийн зүй тогтол юм гэх нь холгүй юм хэлдэг, бичдэг болсон байна. Сэтгүүл зүйн бичлэгийн зарим зүйл нөгөөгөө баяжуулж байхыг үгүйсгэхгүй. Харин хаягдаж, гээгдэж, бүрмөсөн үгүй болж байна гэвэл арай хатуудна. Тэр бол худал. Үүний оронд шилдэг хөрөг, шилдэг эсээ, шилдэг зураглал бичиж чаддаг нь цөөрсөн гэвэл бодит үнэнд илүүтэй нийцнэ. Энэ үүднээс авч үзэх юм бол Х.Наранжаргалын “Телевизийн буурал Жаргал” нийтлэл чамбай, сонирхолтой хөрөг болсон гэж хэлэх байна.

Хөрөг нийтлэлийн төгсгөлийг Х.Наранжаргал ухаалаг зохиомжилжээ. Хийх ёстой шигтгээг хийж, уншигчдад өгөх ёстой мэдээллийг өгсөн байна. Дандаа сайн сайхныг нь шилж түүж түүвэрлэсэнгүй. Хартай, цагаантай хамтад нь дүрслэн үзүүлжээ. Манай үеийнхний дотор Жаргалыг аль ч талд ая тал алддаггүй хүн гэсэн нэг ойлголт явдаг байсан юм. Тэр нь улс төрийн аль ч нам Улсын Их Хуралд олонх болсон ч Жаргал дарга суудлаа алддаггүй байсантай холбоотой болов уу. Үүний уг үндэс, учир шалтгааныг сэтгүүлч Х.Наранжаргал өөрийнхөөрөө гаргаж тайлбарлаж чадсан нь миний сонирхлыг ихэд татав.

“Улстөр хатуу тоглоом учир мэргэжлийн байгууллагад ч өөрийн дүрмийг тулгана. Тэр тусам Засгийн газрын харьяат, мэдээллийн том хэрэгсэлд энэ нь бүр илүүтэй

мэдрэгдэнэ. Үүнд гагцхүү улс төрийн ашиг сонирхол үйлчилдэг...

**А**х намынхан Жаргал даргыг Ардчилсан намын хүн гэх. Ардчилсан намынхан болохоор Хувьсгалт намынх гэх. Яг үнэн нь гэвэл тэр “Телевизийн нь л хүн байсан юм” гэжээ. Энэ бол сэтгүүлч, судлаач Х.Наранжаргалын гаргалгаа. Бараг л оночхож гэж хэлмээр байна. Тэр үнэхээр телевизийн хүн байсан. Тэгэх тэгэхдээ олон олдохгүй онцгой содон телевизийн удирдагчдын нэг байсан. Улс төр талаас нь харж тодорхойлох юм бол Ардын намын угшилтай, Ардчилсан намын зүгшилтэй сэхээтэн байсан юм болов уу гэж нэмье.

“Гурван жилийн өмнө “Намынхаа төлөө саналаа өгөөд үхэх юм сан” гэж үглэсээр амжилгүй аав минь Бурхны оронд залрав. Жаргал дарга эхнэртэйгээ ирлээ. Ижий минь хожим “Нараа их тэвчсэн сэн. Харин Жаргал даргыгаа хараад дусал нулимс унагана лээ” гэж билээ. Аав минь нэг өдөр туйлын баяртай байв. Жаргал дарга утсаар ярьж, биеийг нь асуужээ. Жаргал дарга миний охиныг магтаж байна лээ гэсэн. Аавыгаа амьдад нь баярлуулсан ганц тохиолдол энэ байсан байж магадгүй.

Би Жаргал даргад баярлалаа гэж ганц удаа хэлсэнгүй. Өнөө хэр боломж гарсангүй. Миний мэдэхийн тэр насны ой тэмдэглэж, гавьяа шагнал угааж найрлаж байсангүй...

Тас хар халимагийн тухай эл хөргийн эхэнд би зүгээр ч нэг дурдсангүй. Өнөөдөр Жаргал даргын толгойд ширхэг хар үс байхгүй. Түүнийг буурал Жаргал гэх болж. Түүний толгойд гялалзах мөнгөн сорын ширхэг бүхэнд телевизийн төлөө гэсэн сэтгэл нь шингэсэн байдаг.



“Телевиз бол Жаргал даргын амьдрал” гэсэн үг өгүүлбэрээр “Телевизийн буурал Жаргал” нийтлэл төгсөж байна.

Хав хар халимагтайгаасаа був буурал болтлоо Монголд телевизийн сэтгүүл зүй, телевизийн урлагийг төлөвшүүлэн хөгжүүлэхийн төлөө зүтгэсэн Жаргал дарга сэтгүүлч Х.Наранжаргалын өсөж өндийхөд, уран бүтээлч болж бүрэлдэн төлөвшихөд ямар чухал үүрэг гүйцэтгэсэн нь тов тодорхой ойлгогдож байна. Зөвхөн түүний төдийгүй Х.Наранжаргалын гэр бүлийнхэн аав, ээж хоёрынх нь хувьд ч ямар хүндэтгэлт хүмүүн болох нь мэдрэгдэж байна. Энэ хөрөг “Өдрийн сонин”-ны 2007 оны 8 дугаар сарын 13-ны дугаарт нийтлэгджээ. “Телевизийн буурал Жаргал” нийтлэлийн эхлэл, өрнөл, туйл, тайлал хэсэг хоорондоо гайхалтай сайхнаар холбогдон зохицолдож, нэгээс нөгөө нь урган гарч утга санаагаа нөхцөлдүүлэн гүйцээж байгаа нь тун бахархалтай. Агуулга сэдвийн ийм нэгдэл нийлэмж, дүр дүрслэл, хослол зохицол буюу айзам хэмийн иж бүрэн найрслыг л бид сэтгүүлчийн ур чадвар гэж нэрлээд байгаа юм.

**И**йм шилдэг сайн нийтлэлээр Х.Наранжаргалын шилдэг нийтлэлийн 39-р боть элбэг баян буйг онцлон тэмдэглэе. “Телевизийн буурал Жаргал” хөргөөр жишээлж энд ололт амжилтыг дурдлаа. Урьд нь би Х.Наранжаргалын телевизийн сэтгүүл зүй болоод драмын жүжиг хэрхэн бичих талаарх ном зохиолд нь шүүмж бичиж төвийн сонинуудад нийтлүүлж байв. Миний түүвэр зохиолуудад бүрэн эхээрээ бий. Тийм учраас миний бие энэхүү Өмнөх үгэндээ олон зүйлийг ахин дахин давтаж нуршихгүй. Зайлшгүй

тэмдэглэх ёстой гэснээсээ зарим зүйлийг товчхон хэлнэ.

Жишээ нь Х.Наранжаргалын шилдэг нийтлэлийн 39-р ботийн нэг бүлэгт олон уран бүтээлчдийн цөөнгүй хөрөг орсон байна. Телевизийн салбарын залуу сэтгүүлчдэд бичлэгийн бэлээхэн загвар, амт шимттэй аргачлал. БНМАУ-ын Ардын жүжигчин, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн нэрт кино найруулагч Дэжидийн Жигжидтэй хийсэн телеуулзалт байна. Сценарийг урьдчилан бэлтгэж хэн хэнийг урьж оролцуулбал энэ хүний дүр төрхийг илүү үнэн бодитойгоор товойлгож өгөх вэ гэдгийг Х.Наранжаргал сайтар бодож боловсруулсан нь зохиолын төлөвлөгөөнөөс их тод мэдрэгдэнэ. Холбогдох материалыг уншиж судалж, Дэжидийн Жигжид гэдэг хүн ер нь хэн бэ гэдгийг зохиогч ойлгохыг чухалчилжээ. Бүтээл туурвилуудтай нь ойртож танилцсан байна.

Ингээд теле уулзалтдаа Ардын жүжигчнээ залж, зэрэгцүүлээд жүжигчин С.Гэндэн, Л.Жамсранжав, Б.Дамчаа, Д.Дашнамжил, Д.Найдан нарыг урьж авчирсан байна. Д.Жигжидийн зураг авсан, найруулж тавьсан, үзэгчдийн талархал хүлээсэн уран сайхны кинонуудаас шигтгэж оруулах хэсгүүдээ ч бэлтгэжээ. Өөрөөр хэлбэл урьдчилсан бэлтгэлийг зохиолынхоо төлөвлөгөөний дагуу чинээнд нь тултал бэлтгэж базаасан байна гэсэн үг. Хэнээс юуг асууж өдөөж өгөхөө ч мэдээж бодож боловсруулсан байж таарна.

Х.Наранжаргал асууж, Монголын кино урлагийн одод хариулжээ. Урлагийн алтан үеийнхний нэг алдарт жүжигчин С.Гэндэн “Сэрэлт” киног хийхэд Д.Жигжид оператор байсан. Жигжид тун сайн оператор, овжин

оператор, байгаль ажиглахдаа тун соргог хүн байгаа юм гэж хэлж байна. Ардын жүжигчин Д.Жигжидийн бусдаас ялгарах нэг давуу талыг онцолсон нь энэ. Жигжид бол зөвхөн найруулагч биш бас оператор хүн. Кино урлагийн замналаа зураглаачаар эхэлсэн хүн, тун соргог гэжээ.

Жүжигчин Л.Жамсранжав өндөр нэр хүндтэй, авьяастай, туршлагатай найруулагч Жигжид гуайгаас кинонд тоглох урилга авч оролцсон минь их хувь заяа, энэ хүний гараар орсон нь миний уран бүтээлийн замд тохиолдсон чухал үйл явдал юм гэж хэлж байхад жүжигчин Б.Дамчаа болохоор Жигжид багшид хэд хэдэн онцлог, нарийн аргууд бий. Зохиолоо маш сайн судалдаг, зохиолын дүрдээ тохирох жүжигчнээ, хамтран тоглох хүмүүсийг сайтар судалдаг найруулагч. Өндөр шаардлагатай. Жүжигчдийн санал бодлыг сайн сонсдог, өөрийнхөө санаа бодлыг жүжигчдэдээ ойлгуулж чаддаг найруулагч гэсэн байна.

Уран сайхны “Өглөө” кинонд жанжин Д.Сүхбаатарын дүрд тоглосон залуу жүжигчин Д.Дашнамжил бүр ч сонирхолтой зүйлийг дурсжээ. Тэр хэний ямар дүрд ч тоглохоо эхэн үедээ мэдээгүй гэнэ. Гамингийн дүрд л тоглож таараа гэж бодож байжээ. Тэгсэн чинь Д.Сүхбаатарын зургийг ширээн дээр тавьчихсан, тэрийг харж будаад байсан. Би үнэндээ их гайхсан. Очиж очиж намайг жанжин Сүхбаатарт тоглуулах гэж үү дээ? Намайг “их уурла” гэсэн, “нэг сайхан инээ” гэсэн, “их юм бод” гэсэн. Нэг үг цээжлүүлсэн юмаа. Тэр үгийг хэлүүлсэн. Тэгээд “сэлмээрээ газар шаа, тэгээд уурла” гэж байсан. Энэ бүхнээс би намайг Сүхбаатарын дүрд шалгаж байгаа юм байна гэдгийг мэдсэн гэж ярьжээ.

“Өглөө” кинонд жанжин Д.Сүхбаатар эхнэр Янжмаагийн хамт зах дээрээс дарьганга хийцийн эмээлийн наймаа хийх гэж буй хэсгийн зургийг авчээ. Худалдаачин “жинхэнэ дарьганга хийц дээ, хүү минь наадхаа аваарай. Алдахгүй шүү” гэж хэлэхэд Д.Сүхбаатар “Дарьганга хийц биш байна. Жинхэнэ дарьганга хийц гэдэг чинь энэ -миний аавын эмээл” гэж хэлээд эргэж явдаг хэсгийг бүтээх гэж бүтэн өдрийн ажил болжээ. “Үгүй чи чинь наад хүзүү толгой чинь хаашаа юм, яагаад зүгээр эргэж харж чаддаггүй юм” гэж найруулагчид загнуулжээ. “Би ер нь чадахгүй юм байна” гэдэг бодол төрсөн. Хоол ч хоолойгоор давахгүй байлаа. Тэгээд туслах найруулагч Нагнайдоржоос орой нь “Юу гэж байна. Намайг солино гэж байна уу” гэж асуужээ. Цаадах нь “Үгүй ээ, үгүй. Чамайг чадна гэж байна. Тэр дээл хувцас нь шинэдээд их хатуу байна. Хантаазны зах, дээлийн захыг нь сайн нухаж зөөлрүүлж өг” гэсэн хэмээн хариулжээ. Үнэхээр дээлний шинэхэн зах, малгайны бүч нь Дашнамжилын хүзүү хоолойг хөдөлгөхгүй зууруулж байсан гэнэ.

Энэ яриаг улам сонирхолтой хөгжөөнтэй болгож хөтлөгч Х.Наранжаргал Жигжид найруулагчаас “Өглөө” кинонд “Сэлэм Тогмид” гэж сонин дүр бий. Сэлэм Тогмидыг та ер нь яаж олсон юм бэ гэж асууж байна. Асуултад Жигжид найруулагч жанжин Сүхбаатар хэсэг партизануудтай хамт татуулсан зураг байдаг шүү дээ. Тэр бүлэг хүмүүс дотор хар хурган малгайтай нэг нөхөр сэлэм түшээд сууж байгаа. Тэр зургаас санаа авч манай кинон дотор сэлэмтэй дүр байх ёстой юм байна гэж зохиолч Ванган

хэлсэн. Ингээд Сэлэм Тогмид гэдэг дүр төрж гарсан гэж хариулжээ.

Хөтлөгч халуун яриагаа улам лавшруулж Жигжид найруулагчаас та “Ард Аюуш” кинодоо Чойжилсүрэн зохиолчийг яагаад урьж тоглуулсан юм бэ хэмээн сэдвийг өдөөж өгч байна.

Ард Аюуш гэдэг хүн чинь өндөр биетэй ясархаг хүн байсан юм билээ. Шударга шулуун, хатуужилтай хүн байж. Их зовлон үзсэн, их тэвчээртэй хүн. Эх орон, ард түмнийхээ төлөө амь хайргүй зүтгэж чадсан зоригтон. Дотроо бодоод л, хэнийг тоглуулж болох вэ гээд эрж хайгаад явж байсан чинь зохиолч Чойжилсүрэн гэнэт нүдэнд буугаад ирсэн. Шөнөжин бодогдоод нойр ч хүрээгүй. Тэгж би Ард Аюушийг олж авсан юм хэмээн хариулж байна.

Хөтлөгч түүнээс “Хүргэн хүү” киноны зураг авч байхад тохиолдсон явдлаасаа манай үзэгчдэд ярьж сонирхуулаач хэмээн хөөрөлдөөнөө улам хурцалж байна. Х.Наранжаргал сэтгүүлч теле уулзалтад сайтар бэлтгэж судалгааг маш сайн хийсэн нь эндээс мэдрэгдэж байгаа юм.

“Хүргэн хүү” киногоо хийж байхдаа төсвөө батлуулах гэж Сангийн Яаманд очлоо. Төсвийг хэлэлцэхдээ дургүйхэн байцгаана. Нэг өдөр шууд баталчихгүй шүү дээ. Хоёр дахь өдөр нь очтол тэр хүмүүс хоорондоо ярилцаж байна. Архустайн сангийн аж ахуйд мянган мярнууз хонь шатжээ, урд өдөр нь. Мярнууз хонь маллагчийнх 30-50 мянган төгрөгтэй байж. Боож баадагнаад авдартаа хийчихсэн байсан нь бас хамт шатаж орхижээ.

Би тэднээс асуулаа. Мөнгөө яагаад банканд хадгалуулаагүй байсан юм бол гэж. Энэ хөдөөнийхөн,

ялангуяа малчид чинь төвөгшөөгөөд хамаг мөнгөө авдартаа л хадгалж байдаг юм гэв. Энэ ярианаас санаа авч “Хүргэн хүү” киноны зохиол дээр баян Жамц хэдэн шар худалдаж олж авсан мөнгөө авдартаа хийж хадгалаад, тэр нь хэдэн оготнын идэш болж хохирч буйгаар гаргасан юмаа. Сүүлд Сангийн яамныхан надад “Хүргэн хүү” киноны баян Жамцын үйлдлээс санаа авч малчид мөнгөө банканд хадгалуулдаг болсон шүү гэж хэлж байсан гэжээ.

**Б**аян Жамцын дүрд тоглосон алдарт жүжигчин Д.Найдан “Би Жигжид найруулагчийн “Хүргэн хүү”, “Хөдөөгийн баясгалан”, “Их замын эхэнд” гурван кинонд тоглосон юм байна. Д.Жигжид найруулагч кино зохиолын баатруудынхаа талаар жүжигчдээс их асууж лавлаж санал солилцдог хүн. Тэр хэсгийг юу гэж бодож байна, энэ хэсгийг яаж гаргавал зүгээр вэ. Та түрүүнд нь Жамцын дүрийг бүтээсэн, одоо “Хөдөөгийн баясгалан” киноны Ширнэнгийн дүр ямар санагдаж байна. Яг адилхан болгож болохгүй шүү гэх зэргээр өөрийн санаагаа тоглогч жүжигчдэдээ тун сайн ойлгуулж чаддаг гэж онцолжээ.

Сэлэм Тогмидын дүрийг гэрэл зураг үзээд бодож олсон, баян Жамцын авдар дахь мөнгийг хулгана мэрдэг тухай хэсгийг Сангийн Яамны ажилтнуудын ярианаас санаа авч зохиомжилсон зэрэг маш нарийн ширийн зүйлс энд дүрслэгдэж байгаа юм. Эдгээр нь кино найруулагч Д.Жигжид гэдэг хүний дүр төрхийг тодотгох, уран бүтээл туурвих өвөрмөц арга барилыг нь нээн үзүүлэхэд юугаар ч орлуулшгүй нандин шигтгээ болж өгчээ. Ялангуяа түүний кинонд тоглосон алтан үеийн

алдарт жүжигчдийн амаар олон сонирхолтой баримтыг хэлүүлсэн нь онцгой чухал ач холбогдолтой юм. “Үер” киноны гол дүрд тоглогчийн нэг Оросын алдарт жүжигчин Н.Крючковын яриаг хүртэл нэвтрүүлэгтээ шигтгэж өгсөн байна. ЗСБНХУ-ын Ардын жүжигчин тэр хүн “Би монгол хэл мэдэхгүй хэр нь нөхдийнхөө сэтгэл санаа, хүсэл мөрөөдлийг хамгийн түрүүнд мэдэрдэг байлаа. Надтай хамт ажиллаж байсан Жигжид бол онцгой авьяастай хүн. Тэр ямар ч нөхцөлд, ямар ч хүнтэй ажиллаж чаддаг. Хийх бүтээлээ урдаас сайн боловсруулж бусдад ойлгуулж чаддаг ер бусын хүн. Хамтран ажиллахад урамтай” гэж хэлж байна.

Энэ мэтээр сэтгүүлч Х.Наранжаргал өөрийн туурвисан цуврал телеуулзалтад зохиолч Ч.Лодойдамба, Ардын жүжигчин Л.Нацаг, Э.Оюун, яруу найрагч Ч.Чимэд, Гавьяат жүжигчин О.Рэнчинноров, зураач А.Сэнгэцохио, найруулагч П.Туваанжав, Ардын зураач О.Ядамсүрэн, сэтгүүлч Амбасэлмаа, Улсын хошой аварга малчин М.Минжиг, хошууч И.Батмөнх зэрэг олон хүнийг урьж тэдний дүр төрх, дотоод

ертөнцийг нээж үзүүлсэн байна. Бас ЗХУ-ын нэрт найруулагч Н.Озеров, циркийн алиалагч Олег Попов, кино найруулагч А.Тарковский зэрэг “Улаан ном”-д орсон гэж хэлж болох гадаадын алдартнуудтай хийсэн ярилцлагуудаа ч шилдэг нийтлэлийн номдоо бүрэн эхээр нь оруулжээ.

Тэдгээрээс төлөөлүүлж “Телевизийн буурал Жаргал” хөрөг нийтлэл, Ардын жүжигчин, нэрт кино найруулагч Д.Жигжидтэй хийсэн телеуулзалтын ярилцлагад бяцхан ажиглалт хийсэнээ эрхэм хүндэт уншигч тантай хуваалцлаа. “Танин мэдэхүй, судалгааны бүтээл”-ийнх нь талаарх өөрийн санал бодлыг өмнөх үгийн эхэнд товчлон базаж толилуулсан. Дэлгэрүүлж уншвал чөлөөт хэвлэлийн дэлхий дахины байдал, хүн төрөлхтний хандлага, хүсэл эрмэлзэл хийгээд өнөөгийн Монгол Улс дахь үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх

чөлөө ямархуу түвшинд байгаа талаар хангалттай мэдээлэл олж авах болно. Уг бүлгийн эхэнд “Данида” урт наслах эсэх нь сонин хэвлэл нийтлэгчдээс хамаарна” гэсэн гарчигтай нэг захидал байгаа. Өнгөцхөн харвал “Хөх толбо” сонины эрхлэгч Эрдэнэбаатарын



**Энэ мэтээр сэтгүүлч  
Х.Наранжаргал өөрийн  
туурвисан цуврал теле  
уулзалтад зохиолч  
Ч.Лодойдамба, Ардын  
жүжигчин Л.Нацаг, Э.Оюун,  
яруу найрагч Ч.Чимэд,  
Гавьяат жүжигчин  
О.Рэнчинноров, зураач  
А.Сэнгэцохио, найруулагч  
П.Туваанжав, Ардын зураач  
О.Ядамсүрэн, сэтгүүлч  
Амбасэлмаа, Улсын хошой  
аварга малчин М.Минжиг,  
хошууч И.Батмөнх зэрэг олон  
хүнийг урьж тэдний дүр төрх,  
дотоод ертөнцийг нээж  
үзүүлсэн байна. Бас ЗХУ-ын  
нэрт найруулагч Н.Озеров,  
циркийн алиалагч Олег  
Попов, кино найруулагч  
А.Тарковский зэрэг “Улаан  
ном”-д орсон гэж хэлж болох  
гадаадын алдартнуудтай  
хийсэн ярилцлагуудаа ч  
шилдэг нийтлэлийн номдоо  
бүрэн эхээр нь оруулжээ**



“өдөөн хатгалга”-д өгсөн чөлөөт сонины хэвлэх үйлдвэрийн анхны дарга Х.Наранжаргалын хариу захидал мэт харагдавч агуулгад нь нэвтрэн өнгийж харвал Монголд чөлөөт хэвлэлийг үүсгэн хөгжүүлж төлөвшүүлэх үйл явц тухайн цаг үед ямар нарийн төвөгтэй хүнд бэрх ажил байсныг эрхгүй ойлгуулна. Монголын чөлөөт хэвлэлийн түүхэнд байж байх ёстой чухал баримт бичиг.

“Телевиз миний амьдралд дурсамж бичээс” хэсэг дэх “Хараат бус телевизийн төлөө ажилласан”, “Чөлөөт хэвлэл сан”-г байгуулахад оролцсондоо бахархдаг” гэсэн гарчигтай хоёр материал дээрх сэдвийн утга агуулгыг улам гүнзгийрүүлэн баяжуулж өгнө. Х.Наранжаргал бол “Чөлөөт хэвлэл” үйлдвэрийн анхны даргаар ажиллаж хөл дээр нь босгож өгөөд сүүлд Төлөөлөн Удирдах зөвлөлийнх нь даргаар сонгогдож ажилласан сэтгүүлч. Бас “Глоб интернейшнл” ТББ-ыг үүсгэн байгуулагч, анхных нь гүйцэтгэх захирал. Эдүгээ тус байгууллагын Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна. Ер нь түүний амьдралын сүүлийн гуч гаруй жил Монгол дахь чөлөөт хэвлэлийн үүсэл, хөгжил, төлөвших үйл явцтай яах аргагүй холбогдож гагнагдсан байгаа юм. Тэр бол чөлөөт хэвлэлийн төлөө тууштай тэмцэгч эмэгтэй. Их ч зүйлийг хийж хэрэгжүүлсэн сэтгүүл зүйн салбарын том зүтгэлтэн.

Х.Наранжаргал Монголын чөлөөт хэвлэлийн төлөө үйл ажиллагаагаараа төдийгүй үйлдэл бүтээлээрээ тэмцдэг сэтгүүлч. Телевизийн салбарт ажиллагсад, суралцагч оюутнуудад зориулж сурах бичиг бүтээсэн МУСУИС-ийн хүндэт профессор. Драманы зохиолчдод зориулсан гарын

авлагыг мөн адил. Хэд хэдэн сайхан жүжигтэй, олон улсын уралдааны нэр хүндтэй шагнал хүртсэн нь ч бас бий. Телевизийн болон драмын жүжгийн уран бүтээлүүдээр голлож олон чамбай шүүмж судлалын өгүүлэл бичсэн нь Соёл урлагийн их сургууль, Радио телевизийн дээд сургуулийнхны хувьд эрээд олддоггүй эрдэнэ, сураад олддоггүй сувд болж хэрэглэгддэг гэж сонссон юм байна. Тодорсон авьяастай, торгомсог бичлэгтэй авьяаслаг нийтлэлч гэдэгт эрхэм хүндэт уншигч таныг итгэсэн гэж найдаж байна. Хэлсэн үгтэй, хийсэн ажилтай, тодоос тод мөртэй том уран бүтээлч, хэвлэл мэдээллийн салбарын чадварлаг удирдах ажилтан.

Тэр бээр биднийг төлөөлж олон улсын сэтгүүлчдийн байгууллагын олон хурал зөвлөгөөнд оролцсон байдаг юм. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан нь ч нэг биш удаа. Орос, англи хэлийг төгс эзэмшиж чадсан нь Х.Наранжаргалын бас нэг давуу чанар юм. Энд тэндхийн сонин хэвлэлд нийтлүүлсэн өгүүлэл, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд чөлөөт хэвлэлийн тулгамдсан асуудлаар тавьж хэлэлцүүлсэн олон илтгэлтэй.

“Монголын шилдэг нийтлэл” цувралын 39-р боть Хашхүүгийн Наранжаргалын бүтээл туурвил, үйл ажиллагааны талаар бүгдийг биш ч харьцангуй дэлгэрэнгүй ойлголт мэдээллийг өгч чадна гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь сонирхуулахад 2022 онд Улаанбаатар хотноо хэвлэгдэн гарсан Соёл урлагийн тайлбар толь цувралын “Телевиз” VII дэвтэрт “Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн эвлэлийн дэд ерөнхийлөгч /1996-1999/, Олон улсын сэтгүүлчдийн

холбооны Гүйцэтгэх хорооны гишүүнээр сонгогдон /1998-2007/ ажиллаж байв. 2014-2015 онд Азийн өргөн нэвтрүүлгийн холбоо /ABU/-ны урилгаар Казакстан, Киргизстан улсад хэвлэл мэдээлэл, жөндөрийн сургалт явуулж, гадаадын 40 гаруй хурал, зөвлөгөөнд илтгэл тавьсан. Монгол телевизэд ажиллах хугацаандаа 300-гаад нэвтрүүлэг бэлтгэж, “Телевизийн сэтгүүл зүй” /2006/, “Драмын зохиол бичих замд гарья” /2020/ зэрэг ном хэвлүүлсэн” гэдгийг онцлон тэмдэглэжээ. /Толийн 183-184 дэх талыг хар/

Мөн толийн 33 дахь талд түүний редактороор ажилласан “Анюта” жүжиг, 60 дахь талд “Болд, Эрдэнэ хоёр” жүжиг, 67 дахь талд түүний зохиолоор бүтээсэн “Бэр цэцэг” жүжиг, 32 дахь талд редактораар ажилласан “Итгэл” жүжиг, 160 дахь талд түүний редакторласан “Монголын теле театрын хөгжил” ном, 199 дэх талд “Глоб Интернэшнл” ТББ-аас гаргасан “Олон нийтийн өргөн нэвтрүүлэг” ном, 228 дахь талд Х.Наранжаргалын зохиосон “Санан санан дурсана” телевизийн олон ангит кино, 222 дахь талд түүний редакторласан “Сансарт хүрэх зам” нэвтрүүлэг, 234 дэх талд “Соёл эрдэнэ” нэвтрүүлэг, 244 дэх талд Х.Наранжаргалын “Сүүлчийн улирал” жүжиг, 258 дахь талд редакторласан “Теле уулзалт II” нэвтрүүлэг, 265 дахь талд “Телевизийн сэтгүүл зүйн үндсэн ойлголт, зөвлөмж” номынх нь тухай, 287 дахь талд редактораар ажилласан “Уран бүтээлчийн хөрөг” нэвтрүүлэг, 289 дэх талд зөвлөхөөр ажилласан “Ус дээшээ урсдаг” олон ангит киноны тухай, 291 дэх талд Х.Наранжаргалын зохиолоор бүтээсэн “Ухаант туулай” жүжиг, 313 дахь талд редакторласан “Хөрөг” нэвтрүүлэг, 319 дэх талд

“Хүлээлт” жүжгийн талаарх мэдээллийг тус тус оруулсан байна.

**С**оёл урлагийн тайлбар толь цувралын “Телевиз” VII дэвтэрт сэтгүүлч, драмын жүжгийн зохиолч, телевизийн сэтгүүл зүй ба урлаг судлаач, Монголын чөлөөт хэвлэлийн нэрт зүтгэлтэн, СУИС-ийн хүндэт профессор Хашхүүгийн Наранжаргалын намтар, уран бүтээл, идэвхтэй үйл ажиллагааны талаарх мэдээлэл хорин удаа оржээ. Энэ бол зөвхөн тоон статистик төдийгүй чанарын томоохон үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл Монголын сэтгүүл зүй, ялангуяа түүний телевизийн салбарын 1970-аад оноос хойших өнөөг хүртэлх үйл ажиллагааг Хашхүүгийн Наранжаргал гэдэг уран бүтээлчгүйгээр бүрэн гүйцэд ойлгож төсөөлөхөд бэрх болохыг энэ баримт харуулж байгаа юм. Тэр манай сэтгүүл зүйн түүхэнд өөрийн тодоос тод мөрийг үлдээсэн том уран бүтээлч, ажигч гярхай судлаач мөн гэдгээ батлан харуулж чадсан нэгэн мөн билээ. Үүний тод баталгаа нь “Монголын шилдэг нийтлэл” цувралын 39-р боть болж чадна гэдэгт гүнээ итгэж байна. “Телевиз” хэмээх толь бичигт үйл ажиллагаа, уран бүтээл нь тэмдэглэгдэж, “Монголын шилдэг нийтлэл” цувралын бүхэл бүтэн нэг ботийг бүтээл туурвилаараа дагнан гаргаж байна гэдэг бол олон хүнд олддог тийм ч амархан зүйл биш юм. Алтан мөнгөн суваргаа сүндэрлүүлэн босгосонтой адилтган зүйрлэж болно.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. “Монголын шилдэг нийтлэл” Х.Наранжаргал 39 дүгээр боть. УБ. 2023.
2. “Соёл урлагийн тайлбар толь” цувралын “Телевиз” VII боть. УБ. 2022.

3. Х.Наранжаргал. Телевизийн сэтгүүл зүй. УБ. 2006.
4. Х.Наранжаргал. Драмын зохиол бичих замд гаръя. УБ. 2020.

### **Summary**

Works of journalism and cultural studies, created by Honorary Professor of the University of Culture and Arts of Mongolia Naranjargal Khashkhuu, were published in Ulaanbaatar as the 39th volume of the series “Mongoliin shildeg niitlel”

This volume contains the author’s own methodology for creating television programs, and also analyzes television programs and plays, television journalism from the point of view of content and skill. Moreover, the book includes the author’s best works in the genre of television portraits

In a series of articles devoted to the historical development of a democratic free press in Mongolia, the author shares with readers his vision of a free press, the problems it faces, and its prospects for development.

Dr. T. Baasansuren in his review emphasizes “On some moments of the work of Naranjargal” reveals the achievements and importance of the book.

**Keywords:** TV journalism piece, writing plan, structure, content and skills of teletext. Criticism of television works. Growth and development of free media in Mongolia, challenges and future development. Portraits of some figures in the fields of journalism and culture.